

ЕРІ болон бусад даатгалын шимтгэлийн төлбөрт зориулсан хөнгөлөлтийн систем

Битүүмжилсэн хөрөнгийг албадан борлуулж мөнгөн хөрөнгө болгох ажиллагааг түр хойшлуулах

Хэрэв шимтгэлийг нэг дор төлөх нь бизнесийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж, таны амьжиргаанд саад учруулж болзошгүй бол, битүүмжилсэн хөрөнгийг албадан борлуулж мөнгөн хэлбэрт шилжүүлэх ажиллагааг нэг жил хүртэл хугацаагаар түр хойшлуулах хүсэлт гаргах боломжтой.

Хүсэлтийг шимтгэл төлөх хугацаа дууссанаас хойш зургаан сарын дотор Японы Тэтгэврийн Үйлчилгээний Газар (JPS)-ийн харьяа салбарт гаргана. Хүсэлтийг зөвшөөрсөн тохиолдолд:

- а. Таны хөрөнгийг* битүүмжлэх, эсхүл борлуулах зорилгоор мөнгөнд хөрвүүлэх ажиллагааг түр зогсооно.
- б. Төлбөрийн хугацаанд төлөгдөөгүй шимтгэлд тооцсон алдангийн тодорхой хэсгийг чөлөөлнө.

* Компани (эсвэл бусад хуулийн этгээд) байх үед компанийн (эсвэл бусад хуулийн этгээдийн) хөрөнгө

Анхаарна уу: Хөнгөлөлтөд хамаарах төлбөрөөс гадна бусад хугацаа хэтэрсэн төлбөртэй бол битүүмжилсэн хөрөнгийг албадан борлуулж мөнгөн хөрөнгө болгохыг хойшлуулах хүсэлт гаргах боломжгүй болно.

Даатгалын шимтгэлийн төлбөрийн хугацааг хойшлуулах

Дараах шалтгааны улмаас шимтгэлийн төлбөрийг нэг дор төлөх боломжгүй бол, нэг жил хүртэл хугацаагаар хойшлуулах хүсэлт гаргаж болно:

1. Таны эзэмшиж буй хөрөнгө · гамшигт өртөж сүйдсэн, эсвэл хулгайд алдагдсан
2. Аж ахуйн нэгжийн өмчлөгч, эсвэл түүний нэг өрхийн гишүүн өвчлөх, гэмтэх тохиолдолд.
3. Бизнесийн үйл ажиллагааг зогсоосон эсхүл түр хугацаагаар түдгэлзүүлсэн.
4. Төлбөрийн хугацаа эхлэхээс өмнөх нэг жилийн хугацаанд бизнесийн орлого их хэмжээгээр, тухайлбал, өмнөх жилийн ашгийн талаас илүүгээр буурсан тохиолдолд.
5. Мэдээлэл, тайлангаа хоцроож ирүүлснээс нэмэлт төлбөр төлөх нөхцөл үүснэ.

Дээр дурдсан шалтгаанууд үүссэн тохиолдолд та харьяа JPS-ийн салбараар дамжуулан Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын бүсийн газрын даргад яаралтай хүсэлт гаргах шаардлагатай.

Шаардлага хангасан бол хугацаа хэтэрсэн төлбөрийг хэсэгчлэн төлөх боломжтой.

- а. Таны хөрөнгийг* битүүмжлэх, эсхүл борлуулах зорилгоор мөнгөнд хөрвүүлэх ажиллагааг түр зогсооно.
- б. Төлбөрийн хугацаанд төлөгдөөгүй шимтгэлийн алдангийн тодорхой хэсгийг чөлөөлнө.

Анхаарна уу: Төлбөр төлөх хугацаа дуусахаас өмнө гамшгийн улмаас · таны хөрөнгөд* их хэмжээний хохирол учирсан бол гамшигт нэрвэгдэгсдэд олгох төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдах хүсэлт гаргаж болно.

Тэмдэглэл:

- Хэрэв та шаардах хуудаст заасан хугацаанд төлбөрөө төлөөгүй бол шаардлагын мэдэгдэл (督促状) гаргана;
 - Төлбөр төлөх хугацаа хэтэрсэн өдрийн дараагийн өдрөөс эхлэн, төлбөрийг төлж дуусах хүртэлх хугацааны хоног тутамд алданги тооцогдоно.
 - Таны хөрөнгийг* · хурааж авах боломжтой.
- Даатгалын шимтгэлээ хугацаанд нь төлөхөд хүндрэлтэй байна уу? Таны аж ахуйн нэгжийн байршлын харьяаллын дагуу JPS-ийн салбарт нэн даруй хандаж зөвлөгөө авна уу.

Төлбөрийн хугацааг хойшлуулах системд хүсэлт гаргах арга зам

➤ Өргөдөл болон шаардлагатай бичиг баримтыг харьяалах JPS-ийн салбарт ирүүлнэ үү.

1. Битүүмжилсэн хөрөнгийг албадан борлуулж мөнгөн хөрөнгө болгох болон даатгалын шимтгэлийн төлбөрийн хугацааг хойшлуулах (түр түдгэлзүүлэх) тухай өргөдөл
2. Орлого, зарлага, хөрөнгийн тайлан 財産収支状況書 (Хэрэв хойшлуулах хүсэлт гаргасан дүн 1 сая иенээс их байвал, дээрх тайлангийн оронд Хөрөнгийн жагсаалт 財産目録, болон Орлого, зарлагын дансны тайлан 収支明細書 шаардлагатай.)
3. Хэрэв хойшлуулсан төлбөрийн дүн 1 сая иенээс дээш бол барьцаа хөрөнгийн тухай бичиг баримт гаргаж өгөх шаардлагатай.
4. Гамшигт өртөж гэмтсэн (хохирол) гэдгийг нотлох баримт бичиг (зөвхөн даатгалын шимтгэлийн төлбөрийг хойшлуулах хүсэлтэд хамаарна).

➤ Огноо/Хугацаа гаргах

- Битүүмжилсэн хөрөнгийг албадан борлуулж мөнгөн хөрөнгө болгох ажиллагааг хойшлуулах (түр түдгэлзүүлэх) тухай хүсэлтийг даатгалын шимтгэл төлөх анхны хугацаанаас хойш зургаан сарын дотор гаргана.
- Шимтгэл төлөх хугацааг хойшлуулах тухай:
Өргөдөл гаргах шалтгаан үүссэн даруйд (эсвэл мэдүүлэг хоцорсны улмаас нэмэлт шимтгэл тооцогдсон бол түүнийг төлөх хугацаанд багтаан) өргөдлөө ирүүлнэ үү.

➤ Хариу мэдэгдэх хуудас

- Битүүмжилсэн хөрөнгийг албадан борлуулж мөнгөн хөрөнгө болгох ажиллагааг хойшлуулах:
- Шимтгэл төлөх хугацааг хойшлуулах тухай: Таны хүсэлтийн хариуг Эрүүл мэнд, Хөдөлмөр Нийгмийн Халамжийн Бүсийн Газрын дарга танд мэдэгдэнэ.

Хөнгөлөлт олгосон бол та мэдэгдэлд заасан сар бүрийн төлбөрийн хуваарийн дагуу төлбөрөө төлөх ёстой.

Барьцаа хөрөнгө гаргах тухай

Үндсэндээ, хөнгөлөлт хүсэж буй дүнтэй тэнцэхүйц үнэлгээ бүхий барьцаа хөрөнгө (эсвэл баталгаа)-г бүрдүүлэх шаардлагатай. Барьцаанд дараах зүйлс хамаарна: 1. газар, эсвэл барилга 2. Улсын бонд, эсвэл үнэт цаас 3. Баталгаа гаргагчийн баталгаа
Дараах тохиолдолд барьцаа шаардлагагүй:

- Хөнгөлөлтөд хамрагдах дүн нь 1 сая иен болон түүнээс бага бол
- Хөнгөлөлтийн хугацаа нь гурван сар болон түүнээс богино байвал
- Хэрэв танд барьцаа тавих хөрөнгө байхгүй бол

Хөнгөлөлтийн хугацаа

Төлбөр хойшлуулах хугацаа хамгийн ихдээ нэг жил байна. Харин таны хөрөнгө* болон орлого-зарлагын балансыг харгалзан, таны төлбөрийн чадвартай гэж үзсэн хамгийн богино хугацаагаар хязгаарлана. Хойшлуулалтын хугацаанд хойшлуулсан шимтгэлийг хуваан төлөх үүрэгтэй.

Хэрэв танд зөвшөөрсөн хугацаанд төлбөрөө төлж чадахгүй хүндэтгэх шалтгаан байвал, харьяа JPS-т хугацаа сунгуулах хүсэлт гаргаж болно.. Хугацааг сунгах нь анх олгосон хөнгөлөлтийн хугацааг оруулаад нийтдээ хоёр жил хүртэл байж болно.

Хөнгөлөлт цуцлах тухай

Дараах тохиолдолд олгогдсон хөнгөлөлтийн хугацааг цуцалж болно.

- Хэрэв та хөнгөлөлт олгосон мэдэгдэлд заасан төлбөрөө хугацаанд нь хийгээгүй бол.
- Хойшлуулаагүй бусад шимтгэл хугацаа хэтэрч, төлөгдөөгүй тохиолдолд.

Дэлгэрэнгүй мэдээллийг харьяа JPS-т хандана уу.

Энэ маягтыг бөглөхийн тулд "Хөнгөлөлтийн хүсэлт гаргах гарын авлага (Япон хэл дээр)" үзнэ үү.